



# “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС” ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



2023 он



## Удиртгал

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилгоор Монгол базлыт ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 сарын 30-ны өдрийн 07 дугаартай тогтоолоор Компанийн засаглалын кодекс хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг баталсан болно.

Тус хөтөлбөрийн дагуу хийгдэх ажлын төлөвлөгөө гаргаж, Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хорооны үнэлгээний хянан баталгаажилтад үндэслэн хэрэгжилтийг хангаж 2023 оны 04 сарын 30-ний байдлаар Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээний аргачлалын дагуу үнэлж, тайланг нэгтгэв.

## Үнэлгээний нэгдсэн дүн

№	Кодексын зарчим	Авбал зохих оноо	Анхны үнэлгээ 2022.08	Үнэлсэн оноо 2022.04.30	Хяналтын оноо	Үнэлгээний хувь 2022.04.30
1	ГУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	12		100%
2	ГУЗ-ийн дэргэдэх хороод тэдгээрийн чиг үүрэг	10	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	5	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	5		83,3%
5	Эрсдлийн удирдлага	8	6	7		87,5%
6	Эрх бүхий албан тушаалтын цалин урамшуулал	6	5	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7	8		100%
8	Компанийн соёл	6	5	5		83,3%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	9		90%
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>	<b>62</b>	<b>68</b>		<b>94.4%</b>



**МОНГОЛ БАЗАЛЫТ ХК-ийн компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээний дэлгэрэнгүй тайлан**

**Компанийн засаглалын үнэлгээний асуулга**

Кодексийн хэрэгжилтийг "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..

**НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна**

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	2021 оны 03 сарын 15-ны өдөр "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг шинэчлэн баталж тус журамд гишүүдийн болон нарийн бичгийн дарга, хороодын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан.	2	100%
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	2021 оны 03 сарын 15-ны өдөр "ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам"-ыг баталж үйл ажиллагаанд мөрдөж байгаа болно. Залгамж халааны бодлогыг компанийн үйл ажиллагааны онцлогийг тусган боловсруулж байна.	2	100%
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршилага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Байнга хэрэгжүүлж байна  Цахим хуудас <a href="https://Basaltwool.mn">https://Basaltwool.mn</a>	Компанийн 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан болон 2023 оны эхний улирлын тайланд тусгаж нийтэд мэдээлсэн. Цаашид мэдээллийн ил тод байдлын журмын дагуу байнга байршуулж байхаар журмалсан болно.	2	100%
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	2021 оны 03 сарын 15-ны өдөр "ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам"-уудыг шинэчлэн баталсан ба гишүүдийн боловсрол, мэдлэг ур чадвар, тавигдах шаардлагыг тодорхой тусгасан болно	2	100%
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг,	Байнга хэрэгжүүлж байна	ТУЗ-ийн гишүүд нь 2018 оноос хойш ажиллаж байгаа ба ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд сургалтын ажлыг тусгаж	2	100%



	<i>мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>		зардлыг төсөвт суулгаж баталсан.		
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, хороодын журам болон хууль тогтоомжийн дагуу чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж ирсэн. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд нарийн бичгийн даргын ажлын тайланг тусгасан.	2	100%
ДҮН				12	100%
<b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b> ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зоринo.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн  Компанийн дүрэмд ердийн 6, хараат бус 3 гишүүн байхаар тоог нь зааж өгсөн	Одоогийн ажиллаж байгаа ТУЗ-ийн 5 гишүүн нь хувьцаа эзэмшигч биш бөгөөд хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг бүрэн хангаж байгаа. Үйл ажиллагааны тайлан болон ХЭХурлын материалд холбогдох баримтыг хавсаргаж мэдээлсэн.	2	100%
8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	2021 оны 03 сарын 15-ний өдөр “ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталсан. 2022.05.01-ний өдрийн хурлаар аудитын хорооны дарга, гишүүдийг шинээр томилсон ба кодексын шаардлагыг бүрэн хангасан.	2	100%
9	<i>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	2021 оны 03 сарын 15-ний өдөр Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журмыг баталсан ба Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүнийг 2023.05.01-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар шинээр баталсан. Компанийн цалин урамшууллын бодлогыг Цалин урамшууллын хороо боловсруулна.	2	100%
10	<i>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	2021 оны 03 сарын 15-ний өдөр “ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталж, гишүүдийг 2023.05.01-ний	2	100%



	<i>хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>		өдрийн хурлаар шинээр томилсон.		
11	<i>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	2023.05.01-ний өдрийн хурлаар ТУЗ-ийн дэргэд Эрсдлийн удирдлагын хороог 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар шинээр байгуулсан ба компанийн Эрсдлийн удирдлагын бодлого, хорооны үйл ажиллагааны журмыг боловсруулж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлнэ.	2	100%
ДҮН				10	100%
<b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b> ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	<i>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Байнга хэрэгжүүлдэг <a href="https://Basaltwool.mn">https://Basaltwool.mn</a>	2019.06.05-ны өдөр батлагдсан Мэдээллийн үйл ажиллагааны журмыг баталсан бөгөөд үйл ажиллагаанд мөрдөж байна. Мөн компанийн мэдээллийн өөрийн болон хөрөнгийн биржийн цахим хуудаст байрлуулж, төрийн захиргааны байгууллагад хүргүүлж ажилладаг. Бодлогын баримт бичиг, дүрэм журмыг нээлттэй байрлуулахаар компанийн цахим хуудаст өөрчлөлт оруулж байна.	2	100%
13	<i>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>	Байнга хэрэгжүүлдэг <a href="https://Basaltwool.mn">https://Basaltwool.mn</a>	Цахим хуудаст хувьцаа эзэмшигч нарт болон компанийн засаглалын мэдээллийн цэс байдаг бөгөөд Засаглалын баримт бичиг дүрэм журам, зааврыг тухай бүр оруулж байхаар журмалсан ба одоогийн батлагдсан баримт бичгийг мэдээлсэн.	2	100%
14	<i>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзоишгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго,</i>	Байнга хэрэгжүүлдэг	Санхүүгийн тайланг СТОУС-ны дагуу гаргаж, олон улсын хөндлөнгийн аудитын компаниар баталгаажуулсан ба 2023 оны нэгдүгээр улиралд БОНЗ-ын суурь үнэлгээний тайланг "Ризиленс Консалтинг Сервиз" ХХК-иар гаргуулсан ба зөвлөмж	2	100%



	зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.		дүгнэлтийг цаашдын үйл ажиллагаандаа ашиглана		
ДҮН				6	100%
<b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>					
<b>ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана</b>					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	2021 оны 03 сарын 15-ний өдөр ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан. Эрсдлийн удирдлагын хороо байгуулсантай холбогдуулан Аудитын хорооны чиг үүргийг өөрчилж, журмыг дахин боловсруулж, батална	2	100%
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Аудитын хорооны журамд энэ тухай тусгасан ба 2023 оны 04 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Хөндлөнгийн аудитор "Нексия глобал монголиа аудит" ХХК-ийн аудитор Бат-Оргил оролцож ХЭ-ийг мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.	2	100%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	2023.05.01-ний өдрийн хурлаар ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо, эрсдлийн удирдлагын хороодын үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсанаар одоогийн ажиллаж буй дотоод хяналтын тогтолцоонд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн ба боловсруулалт хийгдэж байна. Дотоод аудитын нэгжийн 2022 оны үйл ажиллагааны нэгтгэлийг Компанийн үйл ажиллагааны тайланд тусгаж мэдээлсэн.	1	50%
ДҮН				5	83,3%
<b>ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>					
<b>ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина</b>					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	2023 оны 05 сарын 01-ний өдөр ТУЗ-ийн дэргэд 5 гишүүний бүрэлдэхүүнтэй Эрсдлийн удирдлагын хороо шинээр байгуулсан. Эрсдлийн удирдлагын бодлогын баримт бичиг,	1	50%



			хорооны үйл ажиллагааны журмыг боловсруулж, батлуулна		
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.		2023 оны 05 сарын 01-ний өдөр ТУЗ-ийн дэргэд Эрсдэлийн удирдлагын хороо байгуулсан. Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар хараат бус гишүүн Ч.Зоригтбаатар ажиллах ба хороо нийт 5 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллана. Эрсдэлийн удирдлагын хороо нь компанийн эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг хангаж, тогтолцоо бүрдүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллана.	2	100%
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч Байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ, Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ зэргийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, эрсдэлийг бууруулах, удирдах үйл ажиллагааг байнга хэрэгжүүлдэг.	2	100%
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь үйл ажиллагаагаа хууль тогтоомжид байнга нийцүүлэн явуулдаг бөгөөд Комплайнсын хяналтын зааврын үлгэрчилсэн загварыг компанийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн боловсруулж баталсан.	2	100%
ДҮН				7	87.5%
<b>ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b>					
<b>Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна</b>					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Байнга хэрэгжүүлдэг	2023 оны 04 сарын 17-ны өдрийн ХЭХурлаас ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг баталсан ба ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар гишүүдийн ажлын гүйцэтгэлийг Нэр дэвшүүлэх хороо үнэлж жилийн урамшууллыг	2	100%



			хамгийн сайн ажиллаж буй 2 гишүүнд олгохоор тусгасан		
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</i>	Байнга хэрэгжүүлдэг	2020 онд Гүйцэтгэх захирлын тушаалаар Цалин хөлсний журам баталж, ажлын бүтээмж гүйцэтгэлтэй уялдуулсан урамшууллын систем нэвтрүүлсэн бөгөөд ажилтнуудын дундаж цалин 2,5 сая төгрөг байгаа ба ИТА нарын цалин, урамшуулал 4 сая төгрөг байна.	2	100%
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн улирал бүрийн үйл ажиллагааны тайланд Гүйцэтгэх захирлын цалин урамшууллын тухай өөрийнх нь зөвшөөрлийг авч тусгадаг. ТУЗ-ийн гишүүд ХЭХ-аас нээлттэй баталсан цалин хөлс авдаг.	2	100%
<b>ДҮН</b>				6	100%
<b>ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</b>					
<b>Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ</b>					
25	<i>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>	Хэрэгжүүлж байна	Компанийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг тодорхойлох, батлуулах ажлыг 2023 оны 2 дугаар улиралд багтаан гүйцэтгэнэ. Компанийн үйл ажиллагааны онцлог, БОНЗ-ын суурь үнэлгээний тайланд уялдуулахаар боловсруулалтын хугацааг хойшлуулсан байсан болно.	2	100%
26	<i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>	Байнга хэрэгжүүлдэг	Компанийн үйл ажиллагааны улирал бүрийн тайланд тухайн улиралд хийгдсэн онцлог үйл явдал, тэдгээрийн оролцогч талууд болон харилцагч, хэрэглэгч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хэрхэн хамгаалж, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж буйг мэдээлдэг.	2	100%
27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн цахим хуудас болон сошиал орчинд мэдээллийг нээлттэй, үр дүнтэйгээр дамжуулж, хэрэглэгч, хамтрагч нараас ирсэн санал хүсэлтэд тухай бүр хариу өгч ажилладаг.	2	100%





28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Байнга хэрэгжүүлдэг	2022 оны 06 сарын 01-ний өдрийн Гүйцэтгэх захирлын тушаалаар Хөдөлмөрийн дотоод журам шинэчилэн баталсан ба ажилтнуудын санал хүсэлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэх зохицуулалтыг бүрэн тусгасан. Хүний нөөцийн бодлогын баримт бичгээр ажилтнуудын суралцах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх нөхцөл шаардлагыг тодорхойлсон байдаг бөгөөд хэрэгжүүлсээр ирсэн болно.	2	100%
<b>ДҮН</b>				8	100%
<b>НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ</b>					
<b>ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно</b>					
29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	2019.06.05-ны өдөр “Компанийн ёс зүйн дүрэм” -ийг баталсан ба Компанийн засаглалын кодексын зарчимд нийцүүлэн шинээр боловсруулж байна.	2	100%
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	“Компанийн ёс зүйн дүрэм” -ийг шинэчлэн боловсруулж, түүнд шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг тусгана.	1	50%
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	Байнга хэрэгжүүлдэг	2019.06.05-ны өдөр “Компанийн ёс зүйн дүрэм” -ийг баталсан ба авлига, хээл хахууль, хууль бус аргаар дэмжлэг авах, давуу байдал бий болгохыг удирдах албан тушаалтан, ажилтнуудад хатуу хориглож зохицуулсан.	2	100%
<b>ДҮН</b>				5	83.3%
<b>ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>					
<b>Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана</b>					
32	<i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i>	Байнга хэрэгжүүлдэг	Компанийн цахим хуудас болон хөрөнгийн биржийн цахим хуудаст компанийн санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, удирдлагын шийдвэрийг тухай бүр тогтмол мэдээлдэг.	2	100%



33	<b>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр, мэдээлэл солилцох цахим орчинг хөгжүүлэхээр "Эм Си консалтинг" ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.	1	50%
34	<b>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	2021 оноос хойш ХЭХурлыг цахим болон цахим танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж байгаа ба хувьцаа эзэмшигчдийн цахим бүртгэл санал хураалтад "Эм Си консалтинг" ХХК-ийн хөгжүүлсэн hural.basaltwool.mn цахим хуудас ашиглаж, дамжуулалтыг Zoom meeting ашиглан хийж ирсэн нь хувьцаа эзэмшигчдийн цаг хугацаа, орон зайнаас хамаарахгүй хуралд оролцох боломжийг бүрдүүлж байдаг	2	100%
35	<b>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</b>	Байнга хэрэгжүүлдэг	Хувьцаа эзэмшигчдээс санал хүсэлтээ гаргах эрхийг нээлттэй мэдээлж, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, санхүүгийн албанаас хүсэлт гаргасан тухай бүр мэдээллийг танилцуулдаг.	2	100%
36	<b>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2022 оны 11 сарын 29-ний өдрийн хурлаар Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам баталсан бөгөөд тухай бүр ТУЗ-өөс зохих журмын дагуу зөшөөрөл авдаг. Мөн үйл ажиллагааны тайланд мэдээлэл тусгадаг.	2	100%
<b>ДҮН</b>				9	90%
<b>НЭГДСЭН ДҮН</b>				68	94.4%

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байхаар Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн зарчмыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд цаашид Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах, хэвшүүлэх, тогтвортой байдлыг бий болгох зорилттойгоор ажиллах болно.



**BASALTWOOL**  
МОНГОЛБАЗАЛТ ХК

“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт